# ХИЛ ОРЧМЫН ОЙ, ХЭЭРИЙН ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ ТАЛААР ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар /цаашид Талууд гэх/ хятад, монголын ард түмний найрсаг харилцааг хөгжүүлж, хоёр улсын хил орчмын ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх, харилцан мэдээлэх, гарч болзошгүй хохирлыг багасгах зорилгоор дор дурдсан зүйлийн талаар хэлэлцэн тохиролцов:

## Нэгдүгээр зүйл

Энэхүү Хэлэлцээрээр хил орчмын ой, хээрийн түймрийн асуудлаар харилцан мэдээлэх, хилээс хоёр тийш 25 км-ийн бүс /цаашид "хилийн бүс" гэх/-д гарсан ой, хээрийн түймрийг унтраах талаар хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

Хил орчмын ой хээрийн түймэр гэж хоёр улсын хил залгаа хошуун, сумын нутаг дэвсгэрт гарсан түймрийг хэлнэ.

## Хоёрдугаар зүйл

1.Талууд хил орчмын ой, хээрийн түймэртэй тэмцэх ажлыг зохион байгуулах эрх бүхий байгууллагыг томилон ажиллуулна.

БНХАУ-ын хувьд эрх бүхий байгууллага нь Улсын Ойн аж ахуйн газар, Монгол Улсын хувьд Монгол Улсын Иргэний хамгаалалтын газар байна.

Талуудын эрх бүхий байгууллага өөрчлөгдвөл энэ тухай дипломат шугамаар нөгөө талдаа нэн даруй мэдэгдэнэ.

2. Талуудын эрх бүхий байгууллагууд нь хил орчмын ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, холбоо барих, гарсан түймрийн талаар харилцан мэдээлэх, хамтран тэмцэх, туршлага солилцох зэрэг асуудлыг жич хэлэлцэн тохиролцоно.

3.Талуудын эрх бүхий байгууллагууд хил орчмын ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түймэртэй тэмцэх мэргэжлийн багийг сургаж бэлтгэх, багаж төхөөрөмжөөр хангах болон шаардлагатай бусад асуудлаар туршлага солилцож, уулзалт зөвлөлгөөн зохион байгуулж байна.

## Гуравдугаар зүйл

1.Талууд гал түймрийн аюултай 3 дугаар сарын 1-нээс 6 дугаар сарын 15, 9 дүгээр сарын 15-наас 11 дүгээр сарын 15 хүртэлх хугацаанд галын аюулгүй байдлыг хангах арга хэмжээг тус тусын үндэсний хууль тогтоомжийн дагуу авч хэрэгжүүлнэ.

2.Талууд өөр өөрсдийн нутагт орон нутгийн ард олны дунд хил орчмын ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар сурталчилгаа явуулж, гарсан түймэртэй тэмцэх талаар сургалт зохион байгуулж байна.

3. Талууд хилийн бүсэд гал түймэртэй тэмцэх мэргэжлийн багийг бүрдүүлж, түүнийг хэрэгцээтэй тоног төхөөрөмжөөр ханган зохих бэлтгэлтэй байлгана.

4.Талууд хил орчмын ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

5. Талууд ой, хээрийн түймрийн талаар сансрын мэдээллийн зургаар солилцож байна.

## Дөрөвдүгээр зүйл

1.Хэрэв хил орчимд ой, хээрийн түймэр гарч нөгөө улсын хил рүү тархах аюул тулгарах тохиолдолд түймэр гарсан тал тогтоосон журмын дагуу нөгөө талдаа нэн даруй мэдэгдэж уг түймэртэй тэмцэх арга хэмжээ авна.

2.Хэрэв нэг Талын хил орчмын ой, хээрийн түймэр нөгөө улсын хил рүү орсон тохиолдолд түймэр өөрийнх нь нутаг руу орж ирсэн тал түймрийг унтраах арга хэмжээ авна.

## Тавдугаар зүйл

1.Аль нэг Талын хилийн бүсэд ой, хээрийн түймэр гарч, нөгөө талаас тусламж хүсвэл нөгөө тал шаардагдах тусламж үзүүлэх ажлын хэсэг, эд материал бүрдүүлж тусламж хүссэн Талын товлосон газарт очно.

2.Талууд нь тусламж үзүүлэх ажлын шуурхай байдлыг хангах зорилгын үүднээс тусламж үзүүлэх хэсгийг улсын хил нэвтрүүлэхэд тухайн улсын үндэсний хууль тогтоомжид заасан журмыг хамгийн хялбарчилсан аргаар гүйцэтгэх үүрэг хүлээнэ. Тусламж үзүүлэх хэсгийг холбогдох хэлэлцээрт заагдсан хилийн боомтуудаар болон Талуудын хилийн төлөөлөгчийн шугамаар харилцан тохиролцож тогтоосон түр гарцаар улсын хил нэвтрүүлж болно.

Тусламж үзүүлэх хэсгийн бүрэлдэхүүнд оролцогчид нь гадаад паспорт, эсхүүл хил орчмын нутаг дэвсгэрт зорчих үнэмлэхээр улсын хил нэвтрэх бөгөөд тусламж үзүүлэх хэсгийн ахлагчид тусламж үзүүлэхээр хүлээсэн үүргийг гэрчлэн эрх бүхий байгууллагаас олгосон хэсгийн нэгдсэн үнэмлэх байна. Онцгой яаралтай тохиолдолд тусламж үзүүлэх хэсгийнхнийг харилцан тохиролцсноор нэрсийн жагсаалтаар нэвтрүүлж дараа нь нэгдсэн үнэмлэх олгоно.

Аль ч тохиолдолд тусламж үзүүлэх хэсгийнхнийг улсын хил нэвтрэх, хилийн бүсэд байхыг дээр дурдсан үнэмлэхийн үндсэн дээр виз шаардахгүйгээр гүйцэтгэнэ.

## Зургадугаар зүйл

Аль нэг Талын хил орчимд ой, хээрийн түймэр унтраах ажилд оролцох нөгөө Талын агаарын хөлөгт Талууд улсын хилийг давах, нутаг дэвсгэрийнхээ зохих хэсэгт нислэг үйлдэх зөвшөөрлийг харилцан олгоно.

Тусламж үзүүлэх ажилд агаарын хөлөг ашиглах тухай шийдвэрийг хөлгийн нислэг хийх маршрут, төрөл, бүртгэлийн дугаар, багийн гишүүдийн тоо, ачааны шинж байдал, хөөрөх, буух газар, хугацааны хамт хүсэлт тавьж буй талын холбогдох байгууллагад

мэдэгдэнэ. Нислэгийг Тал тус бүрийн тогтоосон дүрмийн дагуу гүйцэтгэнэ. Ингэхдээ тусламж үзүүлж буй агаарын хөлгүүд нь нислэг үйлдэх, радио чиглүүлэг хийх, онгоцны буудалд буух, зогсох, түүнээс хөөрөхдөө холбогдох төлбөрөөс чөлөөлөгдөнө.

Шатахуунаар цэнэглэх, бусад материалаар хангах болон техникийн үйлчилгээтэй холбогдсон зардлыг тусламж хүлээн авсан Тал хариуцна.

**Долдугаар зүйл**

Аль нэг Талын хил орчмын нутагт гарсан ой, хээрийн түймрийг унтраахад нөгөө Талаас тусламж үзүүлэхтэй холбогдсон зардлыг шийдвэрлэх асуудлыг Талууд жич тохиролцоно.

Тусламж үзүүлэхээр ирсэн хэсгийнхний хоол, байрыг хүлээн авч буй тал хариуцна.

Түймэртэй тэмцэх явцад тусламж үзүүлэхээр ирсэн хүмүүсээс амь эрсэдсэн, тахир дутуу болсон тохиолдолд тэтгэвэр, тэтгэмжийн асуудлыг нь тухайн хүмүүсийг харьяалах улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

**Наймдугаар зүйл**

Энэхүү Хэлэлцээр гарын үсэг зурсан өдрөөс эхлэн 5 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна. Хэрэв аль нэг Тал Хэлэлцээрийн хүчинтэй байх хугацаа дуусахаас 6 сарын өмнө нөгөө Талдаа Хэлэлцээрийг цуцлах тухайгаа бичгээр мэдэгдээгүй бол уг хэлэлцээр дараа дараагийн 5 жилд аяндаа сунгагдана.

Энэхүү Хэлэлцээрийг Улаанбаатар хотноо 1999 оны 7 дугаар сарын "15"-ны өдөр хятад, монгол хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

**БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ӨМНӨӨС**

齐治家

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ӨМНӨӨС**